



Танин мэдэхүйн хөгжил-I (Тэгш хамруулах боловсрол)


Бие даах ажлын дэвтэр
(I-V анги)



1 Дүрсүүдийг ажиглаарай. Аль нь илүү том бэ ? Дүүргэж будаарай.




2 Аль нь бусадтай харьцуулахад өндөр байна вэ?



3 Дүрсүүдийг ажиглаад дөрвөлжин дүрсийг олж дугуйлаарай.



4 Зураасаар дүрс бүтээгээрэй. Ямар дүрс бүтээснийг хэлнэ үү.



5 Дүрсүүдийг тохирох үгтэй нь зөв холбоорой.




- дугуй
- гурвалжин
- дөрвөлжин



< Сэтгэхүй хөгжүүлэх >


Сурагчийн нэр:



Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1


Зургийг ажиглаад, дутуу зүйлийг олж гүйцээж зурна уу.



(.....)



2

Дүрснээс    дүрсийг олж тэмдэглээрэй.




3

Зургийг ажиглаад, дуурайлган зураарай.



4


Зургаас хүнсний ногоог дугуйлан тэмдэглэнэ үү.



Дууссан: он сар өдөр.....цаг

Өөрийн үнэлгээ:





1 Зургийг ажиглаад ижил болон ялгаатай талыг ярилцаж, бичицгээе.



©DESIGNALRIE



Ижил тал

Ялгаатай тал

2 Зургийг нэрлээд, өгүүлбэр зохиогоорой.




Би малгай өмслөө.




.....
.....
.....
.....

3 Далдлагдсан эд зүйлсийг олж нэрлэн бичээрэй.



.....
.....





1

Зургийг ажиглаад нуугдсан 10 эд зүйлсийг олоорой.




2


Үнэн/Худал эсэхийг тодорхойлж, доогуур нь зурна уу.

- | | |
|--------------------------|------------|
| ▪ Алим хөх өнгөтэй. | Үнэн/Худал |
| ▪ Төмс шар өнгөтэй. | Үнэн/Худал |
| ▪ Лууван цагаан өнгөтэй. | Үнэн/Худал |
| ▪ Байцаа ногоон өнгөтэй. | Үнэн/Худал |
| ▪ Сонгино улаан өнгөтэй. | Үнэн/Худал |

3


Сайн ажигласны дараа дээд хэсгийг цаасаар халхлан доод хэсгийн дүрсүүдийг тогтоосон өнгөөр будах.





1

Мөр бүр дээрх хоёр ижил зургийг олж тэмдэглээрэй.



2


Зааврын дагуу будаарай.

Дугуй – шар болон ногоон өнгөөр

Гурвалжин – улаан болон ягаан өнгөөр

Дөрвөлжин – Хөх өнгөөр

Тэгш өнцөгт – Ногоон




3

Үнэн/Худал эсэхийг тодорхойлж, доогуур нь зурна уу.

- Тэнгэр шар өнгөтэй. Үнэн/Худал
- Нар шар өнгөтэй. Үнэн/Худал
- Машин дөрвөн дугуйтай. Үнэн/Худал
- Бөмбөг дөрвөлжин хэлбэртэй. Үнэн/Худал
- Харандаа бөөрөнхий хэлбэртэй. Үнэн/Худал







1

Дараах дүрсийг гараа салгахгүйгээр зураарай.

Ажиглах хэсэг :


Зурах хэсэг :




2

1 минутийн хугацаанд зураг тус бүрийг анхааралтай ажиглаад, зургаа харахгүйгээр ямар зурагнууд байсныг нэрлэн, зураарай.

Ажиглах хэсэг :




Зурах хэсэг :









1


Зургийг тоон дарааллын дагуу зураасаар холбож, өнгөөр ялган будаарай.



2

Амьтдын нэрийг зөв бичээд, өгүүлбэр зохиоцгооё.

 <p>ХҮЭР -</p>	 <p>УГАЛТ -</p>
 <p>МРЬО -</p>	 <p>АНУГА -</p>
 <p>ЭЭМЭТ -</p>	 <p>ОТГОБ -</p>



< Сэтгэхүй хөгжүүлэх >

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1 Цэгийн оронд улирлын нэрийг бичээрэй.



2 Асуултын дагуу ярилцаарай.

- Цэцэг хэзээ дэлгэрдэг вэ ?
- Ямар улиралд бороо ордог бэ?
- Цас хэзээ ордог

.....
.....

3 Цаг хугацаа заасан үгийг олоод доогуур нь зурж хуулан бичээрэй.

1. Цас, бороо, салхи, шуурга, мөндөр.
2. Өнөөдөр, маргааш, өчигдөр, уржигдар.
3. Шар, ногоон, улаан, цэнхэр

.....


4 “Хавар” сэдвээр богино эх зохион бичигчгээ.

Өгүүлбэр зохион бичих хэсэг:

Дууссан: он сар өдөр.....цаг

Өөрийн үнэлгээ:












< Сэтгэхүй хөгжүүлэх >

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1 Зургаас илүүц зүйлийг олоорой.



2 Цэгийн онрд тохирох үгийг нөхөж бичээрэй.




..... нар манддаг.

..... нар өндөрт хөөрнө.

..... нар жаргадаг.


3 Зөв нэрлэж, нөхөж бичээрэй.



Дууссан: он сар өдөр.....цаг Өөрийн үнэлгээ:

< Сэтгэхүй хөгжүүлэх >


Сурагчийн нэр:




Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1 Яг одоо хэдэн цаг болж байгааг тэмдэглээрэй.


Жишээ нь :




Тэмдэглэх хэсэг :




2 Өгөгдсөн цагуудыг тэмдэглэж, хэдэн цаг болж байгааг ярилцана уу.




10:00



7:00



8:30



11:30

3 Дараах зурагнуудаас амьд биетийг олж + тэмдэг тавиад, нэрлэн бичээрэй.



.....



.....




.....



.....



.....



.....



.....




.....

Дууссан: он сар өдөр.....цаг

Өөрийн үнэлгээ:






1

Нийт хэдэн мод, хэдэн цэцэг байгааг тоолж, тоог нь бичээрэй.

..... мод

..... цэцэг



2

Зөв холбож, өгүүлбэр бүтээгээрэй. Жишээ нь : Батаа алим идэв.



Батаа

алим

өмсөв.

дуу

идэв.

захиа

дуулав.

малгай

бичив.

3

Зургийг ажиглаад, эсрэг үйлдлийг холбоорой.



унтах



зогсох



өгсөх



уруудах




суух



сэрэх






Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1 Зааврын дагуу будаарай.

Дугуй – шар болон ногоон
Гурвалжин – улаан болон ягаан
Дөрвөлжин – Хөх
Тэгш өнцөгт – Ногоон



2 Дутуу бичигдсэн үгийг зөв нөхөж бичэ

үзэг	харандаа	бал
харандаа	бал	
бал		

үхэр	хонь	ямаа
хонь		үхэр
ямаа		хонь

3 Үсгүүдээр үг бүтээцгээе.

С	А	Р	О	Д
А	М	Ө	Ө	Г
Р	А	И	А	А
А	Л	А	А	Л
Н	О	М	Э	Ү



4 Эхийг уншаад, хуулан бичээд, цэгийн оронд эгшиг нөхөж бичээрэй.


Намар

Намар болов. Энэ намар самар, жимс элбэг ургалаа. Усны шувууд буцлаа. Өвс ногоо шарлаж, модны навч унав.



сам . р , навч . с, элб . г,
шув . . д, н . гоо, м . д, . вс,





1 Эхийг уншаад, ярилцаарай.

Болдоо хүү

Болдоо хүү өвөө, эмээ, аав, ээж, ах, эгч нартайгаа хамт байгалийн үзэсгэлэнтэй газраар аялав. Тэнд уул, хад, ургамал, ногоо, амьтан мөн гол урсаж байв. Тэд замдаа нэгэн газар түр амрахаар зогсов.



Гэтэл нэгэн эмээ санаандгүй гутлынхаа үдээсэнд бүдрэн унах дөхөв. Эмээ унахдаа барьж байсан цүнхээ алдав. Болдоо хүү эмээд очиж тусаллаа.

2 Дараах асуултад хариулаарай.

1. Болдоо хүү хаашаа явсан бэ ?

.....

2. Хэн хэнтэйгээ хамт явсан бэ ?

.....

3. Тэнд юу юу байсан бэ ?

.....

4. Эмээ яагаад унасан бэ ?

.....

5. Эмээ юу барьж явсан бэ ?

.....

3 Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичнэ үү.

Чарга


Хүйтэн өвөл Цав цагаан цас орлоо.
Хүүхдүүд цас цас гэж баярлан Хүүхдүүд чаргаа
..... ууланд гарлаа. Өндөр уулын бэлд чаргатай
..... дүүрэн байна.



Нөхөх үгс :

аваад, эхлэв, хүүхдүүд,
будран, гүйлдэнэ,





1 Зургийг ажиглаад, юуны зураг болохыг нэрлэцгээе. Зурган дээр хэдэн шагай байна вэ ?



2 Шагай хэдэн талаараа буудаг вэ ? Нэрлэн бичээрэй.



Four empty rectangular boxes for writing the number of sides and the name of the object.


3 Амьтдыг нэрлээд, зөв холбоорой.



ЯМАА



ХОНЬ




ТЭМЭЭ

МОРЬ











Three empty circles for a self-rating scale.







1

Шагайнаасаа 4 ширхэгийг ялгаж аваарай. Хамт байгаа хүнтэйгээ 4 шагайгаа ээлжлэн орхиж, дараах хүснэгтэд тоог нь бичээрэй. Ээлжлэн хүн тус бүр 5 удаа орхиорой.

Таны нэр:					Таны хамтрагчийн нэр:				
 Морь					 Морь				
 Тэмээ					 Тэмээ				
 Хонь					 Хонь				
 Ямаа					 Ямаа				

2


Хүснэгтээсээ хараад хэн хэдэн морь, хэдэн тэмээ, хэдэн хонь, хэдэн ямаа буулгаснаа хамтран тоолж бичээрэй.

 Морь	 Хонь	 Тэмээ	 Ямаа

3


- Шагай, эвлүүлдэг тоглоом, савх, өнгийн харандаа гэх мэт тоолж болох жижиг зүйлсийг бэлтгээрэй. Эдгээр зүйлсээс таамгаар атган авч ширээн дээрээ тавиарай.
- Атгаж авсан зүйлээ тоолоорой. Хэд байгааг хамтрагчдаа /найз, ах, эгч, дүү, аав, ээж, багш, эмээ, өвөө/ хэлээрэй.
 - Хамтрагчийхаа тоолсныг шалгаж үзээрэй. Алдаа гаргасан бол дахин тоолуулаарай.
 - Өөрийнхөө тоолсныг хамтрагчаараа тоолуулаарай. Алдаа гаргасан бол дахин тоолоорой.
 - Өнгөөр нь ялгаж тоолоорой.






1 Хамтдаа тоон картууд хийе.

Хийсэн картуудаа дасгал ажиллахдаа ашиглаж байх болно.
Цаасан дээр тоо бичсэнтэй адил цаас хайчилж, тоо бичнэ.




2 Бичгийн цаасыг 4 ширхэг шагай багтах хэмжээгээр хайчлаарай.

Хайчилсан цаасан дээрээ тоонуудыг дуурайлган бичээрэй.
0,1,2,3,4,5,6,7,8,9,10 тоо тус бүрийг 10 ширхэг хийгээрэй.




3 Өмнөх хичээлээр хийсэн тоон картуудаа бэлтгээрэй. Бүх тооноос өөртөө болон хамтрагчдаа тус бүр 1-ийг аваарай. Тоо бичээгүй хоосон цаас бэлтгэсэн байна.

Тоон картуудаа ашиглан дараах байдлаар тоглоорой:




- Ширээн дээр өөдөөсөө харж сууна. Тоон картуудаа доош харуулан тавина.
- Нэг карт сонгон авч, хамтрагчдаа харуулаад, буцааж доош харуулан тавина.
- Хамтрагч харж тогтоосон тоогоо цаас эсвэл дэвтэрт бичнэ.
- Зөв бичсэн бол 1 шагайгаар шагнана.
- Одоо дээрх үйлдүлийг хамтрагч тань танаар хийлгэнэ.
- Хамтрагчийнхаа харуулсан тоог сайн тогтоож аваад, цаас, дэвтэрт бичнэ.
- Хамтрагч тань таныг зөв бичсэн тохиолдолд 1 шагайгаар шагнана.



Хамтран тоглосон найздаа талархал илэрхийлээрэй.





1 Тоонуудыг уншаад орхигдсон тоог гүйцээж бичээрэй.


1 2 3 ... 5 ... 7 8 ... 10

2 Дүрсүүдийг шувуудтай ижил өнгөөр будаарай.



3 "Тоглоом тоглоцгооё" Зурагт өгөгдсөн дүрсүүдийг бэлтгээрэй.

- Ширээн дээрээ дуртай 2-3 дүрсээ гаргаж тавиарай. Дүрсүүдээ сайн ажиглан тогтоож аваарай.
- Дараа нь нүдээ аниарай. Нэг дүрсийг нь таны хамтрагч нууна.
- Нүдээ нээгээд ямар дүрс нуусныг хэлээрэй.



Дараагийн удаад хамтрагчийнхаа нүдийг аниулаад та дүрс нууж тоглоорой.


Энэ тоглоомыг хэдэн ч удаа тоглож болно. Олон дүрс цуглуулсан нь хожно.

4 Түргэн хэллэгийг цээжлээд, хурдан, түгдрэлгүй хэлж сурцгаая.


*Мөнгөн хонх
Хөнгөн цонх
Ганган данх
Нимгэн лонх*




Four empty circles for rating.



1 Зураг дээр ямар амьтан хэд байгааг тоолоод дөрвөлжин дүрс дотор бичээрэй.



2 Таван хошуу мал болон төл малыг зөв холбож зураарай.



3 Таван хошуу малыг нэрлэн бичээрэй.


.....

.....


.....

.....





.....




1 Ажиглаад хамгийн урт олсыг улаан өнгөөр будаарай. Хамгийн богино олсыг ногоон өнгөөр давхарлан будаарай



2 Доорх дүрсүүдийг дуртай өнгөөрөө будаарай. Хэсэг бүр дэх дүрсийг тоолоод, тоотой зөв харгалзуулан холбоорой.




3 Тоон шулуун дээр орхигдсон тоог бичээрэй





0 1 2 4 6 7 9



○○○



1 Зургийг ажиглаад 5 ялгааг олж, нэрлээрэй. Өнгөөр ялган будаарай.



2 Анги болон гэртээ эдгээр дүрстэй төсөөтэй эд зүйлсийг нэрлэж бичиггээе.



.....
.....

3 Зурагт өгсөн зүйлсээр ямар дүрс зурж болох вэ? Дуурайлган зураарай.




-





4 Дүрсийг үргэлжлүүлэн дарааллын дагуу будаарай.






1 Зургуудыг ажиглаад, 5 ялгааг олоорой. Дутуу зүйлсийг гүйцээж зурснаа ярилцаж, өнгөөр будацгаая.





2 Дэгдээхэйнүүдийн тоог ажиглаарай. Дутуу тоог нөхөж, ямар тоо бичсэнээ нэрлээрэй.



3 Хүснэгтэн дэх тоо тус бүрийг 1 минутын турш сайтар ажиглаад, хугацаа дуусмагц тоотой хүснэгтийг цаасаар дараад, цээжилсэн тоогоо тохирох нүдэнд бичээрэй.


5	9	13
15	6	8
1	10	7

4 Дутуу байгаа төл малыг нэрлэж бичээрэй.




.....
.....





- 1 Алинд нь их шингэн багтах вэ? Сайтар ажиглаад ярилцаарай. Их шингэн багтах савны доор дугуй дүрс, бага шингэн багтах савны доор гурвалжин дүрс зураарай.


Жишээ нь :



- 2 Шингэн хэмжиж сурах дасгалыг хамтран хийгээрэй.

- а) 2 өөр сав, ижил хэмжээтэй аяганууд бэлтгээрэй.
- б) 2 савандаа ус дүүргэнэ.
- в) Эхний савтай усаа ижил хэмжээтэй аягануудад хийнэ. Хэдэн аяга болсныг тоолно.
- г) нөгөө савтай усаа мөн аягануудад хийнэ. Хэдэн аяга болсныг тоолно.
- д) Сав тус бүрд хэдэн аяга ус багтах талаар ярилцаарай.





1 Доор зургийг сайтар ажиглаад, ярилцаарай.

Хамтдаа наамал хийе. Бэлтгэх зүйлс : -навч, бичгийн цагаан цаас, цавуу, хайч, фломастер бэлтгээрэй. Наамлуудыг сайтар ажиглаад дуурайлган хийгээрэй.



2 Шүлгийг цээжлээд, уран тод уншиж сураарай.

Анхны цас

Уулсын сүрлэг оргилоор
Уудам талын энгээр
Урт хөндийн эхээр
Ус мөрний саваар


Таримал модны мөчир дээр
Таван гудамж зам дээр
Таны миний малгай дээр

Ариг цэвэрхэн
Ариун цагахан
Анхны цас орж байна
Танан барилгын дээвэр дээр

Ариг цэвэрхэн
Ариун цагахан
Анхны цас орж байна.

(Ж.Дашдондог)





1 Гурвалжин дүрсний дарааллыг 5-10 секунд ажиглаад, гурвалжин дүрсний өнгийг дарааллын дагуу нэрлэж, будаарай.

Хувилбар 1.

Ажиглах эх материал




Будах хэсэг:




Хувилбар 2.

Ажиглах эх материал




Будах хэсэг:




Хувилбар 3.

Ажиглах эх материал



Будах хэсэг:





2 Эх зургийг 5-10 секунд ажиглан тогтоож, зурагт ямар, ямар өнгө орсон байсныг ярилцаад, будаарай. Зөв будсан эсэхээ шалгаарай.

Эх зураг:




Будах зураг:






1 Зургийг 5-10 секунд ажиглаарай. Аль, аль дүрснээс 2 дахь загас бүтсэн бэ? Дүрслэн хэлээрэй.

Ажиглах эх зураг:



Ашиглах дүрсүүд:



2 Зургийг ажиглаад, асуултын дагуу ярилцацгаая. Зургийг 10 секунд ажиглана.

Ажиглах эх зураг:



Асуултууд:

- Зураг дээр хэдэн хүүхэд тоглож байсан бэ?
- Хэдэн охин, хэдэн хүү элсээр тоглож байсан бэ?
- 2 охин юугаар тоглож байсан бэ?
- Бөмбөг ямар өнгөтэй байсан бэ?
- Өөр юу, юу дүрслэгдсэн байсан бэ?
- Хамгийн цаад талд зогсож байсан охин ямар өнгийн цамцтай байсан бэ?


3 Юу дутуу байгааг олж хэлээрэй. Эх зургийг 10 секунд ажиглуулна.

Ажиглах эх зураг:




Ажиллах зураг:






1 Геометрийн дүрсүүдийг 10-15 секунд ажиглуулна. Тогтоосон дүрсүүдээ зураарай.

Тогтоох дүрсүүд:



Зурах талбай:



2 Тогтоосон үсгүүдээ цээжээрээ бичээрэй. Ажиглах хугацаа 10-15 секунд байна.

Ажиглах үсгүүд:




Хувилбар 1: **А, С, И** Хувилбар 2: **ь, м, э, ё, ц** Хувилбар 3: **Ш, э, м, ь, К, л, р**

Бичих талбар:


Хувилбар 1


Хувилбар 2

Хувилбар 3



3 Доорх хэсэгт өөрийн мэддэг геометрийн дүрсүүдээ зураарай.





1

“Юу өөрчлөгдсөн байна вэ?” тоглоом тоглоцгооё.

10 зураг үзүүлж, 10-15 секунд ажиглуулна. Дараа нь 3 зургийг хурааж авна. Сурагч алга болсон зургийг нэрлэнэ.

Тогтоох эх зургууд:



Ажиллах материал:




2

Зураг дээр аль дүрс байсан бэ? Нэмэх тэмдгээр тэмдэглэнэ үү.



Ажиглах зураг:



Ажиллах талбар :



3

Өгөгдсөн тоонуудыг 30 секунд ажиглаарай. Асуултад хариулаарай.


Хувилбар 1 Ажиглах тоонууд: 3, 5, 4, 7, 8

- Асуултууд:
- Баруун талаасаа 4 дэх тоог нэрлэнэ үү.
 - 3 ба 4-ын тооны хооронд хэдийн тоо байсан бэ?
 - Ямар 2 тооны нийлбэр 10 болох вэ?
 - Эхний 3 тооны нийлбэр хэд болох вэ?
 - Эхний ба сүүлийн тооны нийлбэр хэд болох вэ?

Хувилбар 2 Ажиглах тоонууд: 10, 5, 4, 7, 2

Асуултууд:

- Эхний тооноос сүүлийн тоог хасахад ялгавар хэд гарах вэ?
- 2 ба сүүлийн тооны үржвэр хэд гарах вэ? гэх мэт.



1 Шинэ үг дээр ажиллацгаая.

- Зургийг нэрлэж, бичээрэй.



.....



.....



.....

- Дараах үгийн утгыг тогтоож аваарай.

Тээрэм – будааг гурил болгох хэрэгсэл

Тээрэмдэх – тариа, будааг тээрэмд оруулж гурил болгох

2 Шүлгийг цээжилцгээе.

Тариа будаа хоёр

Тариа будаа хоёрыг
Тарьж ургуулдаг юм
Тарьсан хойноо түүнийг
Хурааж авдаг юм
Тансаг сайхан тариагаа
Гурил болгож тээрэмдээд
Та бидний иддэг
Талх боовыг хийдэг юм




(Н.Цэдэвсүрэн)

3 Шүлэгт гарч байгаа зүйлсийг зураарай.

Blank box for drawing

Three empty circles for rating



1 Шүлгийн тухай асуултад хариулж ярилцаарай.

- Юуг тарьж ургуулдаг бэ?
- Тариа, будааг хэдийд хурааж авдаг вэ?
- “Тээрэмдэх” гэсэн үгийн утгыг хэлээрэй.
- Гурилаар хийсэн ямар бүтээгдэхүүнд чи дуртай



2 “Тариа будаа хоёр” Шүлгийг цээжлээрэй.

3 Эхийг сонсоод, утгыг зурж үзүүлээрэй.





Цасан өвгөн


Удахгүй шинэ жилийн баяр болно. Бид өнгөрсөн амралтын өдрөөр цасан хүн хийлээ. Эхлээд цасан бөмбөлгүүд урлав. Батын цасан өвгөн том, Дулмаа, Чимгээ хоёрынх арай жижиг, харин минийх хамгийн жижигхэн цасан өвгөн болсон байв. Бид цасан хүмүүсээ харж ихээхэн баярлацгаав. Бат, Дулмаа, Чимгээ нар цасан өвгөнийхөө гарыг цасаар, харин би мөчрөөр хийсэн байв. Хамрыг луувангаар, нүдийг нь дугуй дүрсээр хийсэн. Мөн өөрсдөө цасан хүмүүсээ чимэглэв.

Батын цасан хүн


Дулмаа, Чимгээ нарын
цасан хүн

Миний цасан хүн





1 Зургийг ажиглаад, “Манайх” сэдэвтэй эх зохион ярилцаарай.



Эх зохион бичих хэсэг :

2 “Би эхлээ, чи үргэлжлүүлээрэй” тоглоом тоглоё. Эхний хүүхэд ерөнхий нэрлэсэн үг хэлэхэд дараагийн хүүхэд аль болох олон үг нэрлэнэ. Жишээлбэл:

- “Хувцас” гэхэд цамц, өмд, оймс, хүрэм, бээлий гэх мэт
- “Амьтан”-
- “Сав суулга”-
- “Тавилга”-
- “Хичээлийн хэрэгсэл”-



3 “Зөв нэрлээ” тоглоом тоглоё.

Тоглоомд хэдэн ч хүүхэд оролцож болно. Оролцогчид нэг нэгээрээ ажиглана. Хүүхдүүд ямар нэгэн зүйлийг ширээн дээр ээлж ээлжээрээ тавина. Дараа нь ажиглагч хэн, хэн, ямар дарааллаар юу тавьсанг хэлнэ. Энэ маягаар үргэлжлүүлэн тоглоно.





Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1 Гурван эгнээ үгсийг 1 удаа уншиж сонгоно. Дараа нь эгнээ тус бүрийн эхний үгийг хэлэхэд, дараагийн 2 үгийг санаж хэлээрэй.

Сонсох үгс:

Санах үгс:

I эгнээ	II эгнээ	III эгнээ
нэхмэл	утас	цамц
сарнай	ваар	цэцэг
од	нар	сар
гурил	хөөлгөгч	мантуу
цонх	дээвэр	байшин
хүүхэд	залуу	хөгшин
хүүхдүүд	ээж	аав

I эгнээ	II эгнээ	III эгнээ
нэхмэл		
сарнай		
од		
гурил		
цонх		
хүүхэд		
хүүхдүүд		

2 Сонсоод, шинэ үг бүтээцгээе. Эгнээ бүр 3-7 үгнээс бүтнэ. Эгнээ тус бүрийн үгсийн эхний үсгүүдийг дарааллын дагуу санахад шинэ үг бүтнэ.


Сонсох үгс:

1-р эгнээ	машин, айл, лууван
2-р эгнээ	бар, айраг, ямаа, Рагчаа
3-р эгнээ	хот, өмд, даам, өлгүүр, өмд
4-р эгнээ	байшин, ялаа, лам, уул, улс
5-р эгнээ	сур, уурга, Равдан, аймаг, гал, чулуу
6-р эгнээ	зурам, ургамал, сум, лаа, асар, намар
7-р эгнээ	тор, ээмэг, мөс, цас, эм, элэг, найз

3 Бүтээсэн шинэ үгнүүдээ бичээрэй :

1-р эгнээ	Мал
2-р эгнээ	
3-р эгнээ	
4-р эгнээ	
5-р эгнээ	
6-р эгнээ	
7-р эгнээ	





1 Сонгосон үгсийг давтаж хэлнэ. 1 үгнээс эхлээд хүүхдийн нэрлэж чадах эгнээ хүртэл үргэлжлүүлнэ.

Үг хоорондын зай - 1 секунд байна. Үгсийг зөв давтсан тохиолдолд дараагийн эгнээ рүү шилжинэ. Буруу нэрлэсэн тохиолдолд хоёрдахь оролдлогыг хийж болно.


Сонголд өгөх үгс:	1. гал
	1. байшин, сүү
	1. морь, мөөг, зүү
	1. тахиа, нар, зам, дэвтэр
	1. дээвэр, хожуул, ус, лаа, сургууль
	1. харандаа, машин, ах, шохой, шувуу, талх
	1. бүргэд, тоглоом, царс, утас, шил, хүрэм, хүү
	1. уул, хэрээ, цаг, ширээ, цас, ном, нарс, зөгий
	1. бөмбөг, алим, малгай, лууван, сандал, эрвээхий, автобус, тахиа, оймс
	1. машин, чулуу, жимс, цүнх, чарга, алх, охин, ширээ, тарвас, хөшөө


2 Хэлсэн үгсийг цээжлээрэй. Тэдгээр үгсийг оролцуулан эх зохиож хэлнэ үү.

Цээжлэх үгс: цэцэг, хавар, үрээ, ухна, услана, нар, нүх, тарина, хар шороонд, суулгана, хэрэгтэй

Жишээлбэл: Хавар цэцэг тарина. Нүх ухна. Хар шороонд үрээ суулгана. Цэцгээ услана. Цэцэг ургахад нар хэрэгтэй.

3 Дараах зургийг сайтар ажиглаарай. Ойд байдаг амьтад, ургамал, модыг нэрлэж бичээрэй. Жишээ нь : - чоно, самар, нарс гэх мэт.





Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1 Сонсгосон үгсийг давтаж хэлнэ. 1 үгнээс эхлээд хүүхдийн нэрлэж чадах эгнээ хүртэл үргэлжлүүлнэ.

Үг хоорондын зай - 1 секунд байна. Үгсийг зөв давтсан тохиолдолд дараагийн эгнээ рүү шилжинэ. Буруу нэрлэсэн тохиолдолд хоёрдахь оролдлогыг хийж болно.

Сонсгох үгс:

1. гал
2. байшин, сүү
3. морь, мөөг, зүү
4. тахиа, нар, зам, дэвтэр
5. дээвэр, хожуул, ус, лаа, сургууль
6. харандаа, машин, ах, шохой, шувуу, талх
7. бүргэд, тоглоом, царс, утас, шил, хүрэм, хүү
8. уул, хэрээ, цаг, ширээ, цас, ном, нарс, зөгий
9. бөмбөг, алим, малгай, лууван, сандал, эрвээхий, автобус, тахиа, оймс
10. машин, чулуу, жимс, цүнх, чарга, алх, охин, ширээ, тарвас, хөшөө

2 Хэлсэн үгсийг цээжлээрэй. Тэдгээр үгсийг оролцуулан эх зохиож бичээрэй.

Цээжлэх үгс: цэцэг, хавар, үрээ, ухна, услана, нар, нүх, тарина, хар шороонд, суулгана, хэрэгтэй

Жишээлбэл: Хавар цэцэг тарина. Нүх ухна. Хар шороонд үрээ суулгана. Цэцгээ услана. Цэцэг ургахад нар хэрэгтэй.




3 “Ойд зугаалъя” сэдвээр хүүхдэд ярьж өгнө. Ойн амьтад, ургамал, модыг нэрлэж хэлээрэй. Дараа нь ойд юу, юу байдгийг нэрлэж хэлүүлээрэй.

Сонсголд өгөх үгс:

туулай, чоно, самар, нарс, хус,

цэцэг, хуш, хэрэм, хөхөө, үнэг





1 “Амьтны хүрээлэн” сэдвээр ярилцаарай.

Хүүхдийг нүдээ аниад, амьтны хүрээлэн үзэж байгаагаар төсөөлөөрэй. Амьтдыг нэрлэнэ. Одоо нүдээ нээгээрэй. Нэрлэсэн амьтдыг олж тэмдэглээрэй.



Нэрлэсэн амьтад:

- 1. буга
- 2. нохой
- 3. галуу
- 4. чоно

- 1. тогос
- 2. мэлхий
- 3. нугас
- 4. тахиа

- 1. хандгай
- 2. одой морь
- 3. баавгай
- 4. ямаа


2 Амьтдын нэрийг бичиж сурцгаая.



.....




.....



.....



.....




.....



.....





1 Зургийг ажиглаад, юу, юуны зураг байгааг тогтоож аваарай. Тогтоосон үгсийг 30 минут, 1 цаг, 1 өдрийн дараа асуугаарай.

Ажиглах зураг:



2 Асуултад хариулаарай.

-Хувцаснуудыг нэрлээрэй.

-Ямар, ямар тавилгын зураг байсан бэ?

-Санаж байгаа хүнсний ногоогоо нэрлэж, яаж ашигладаг талаар ярилцаарай.

Хувцас

Тавилга

Хүнсний ногоо


.....
-------------------------	-------------------------	-------------------------

3 Утгын холбоо бүхий үгсийг цээжлээрэй.

Цээжлэх үгс:

сандал ширээ, оймс гутал, газар шороо, цаг хугацаа, хоол хүнс





1

Цээжилсэн үгсийг 10 минут, 30 минут, 1 өдрийн дараа асуугаарай.

Эхлээд холбоо үгсийн нэгдүгээр үгийг хэлэхэд хоёрдугаар үгийг хэлж холбоно. Дараа нь эсрэгээр хэлүүлж болно.

Нэгдүгээр хувилбар	Хоёрдугаар хувилбар
сандаг-..... - ширээ
оймс-..... - гутал
газар-..... - шороо
цаг-..... - хугацаа
хоол-..... - хүнс

2

“Байраа олоход нь туслаарай” тоглоом тоглоё.

Амьтад дэлгүүрт дугаарлан зогсоно. 1-д заан тугал, дараа нь унага, 3-т тоорой, дараа нь мууры зулзага, бамбарууш, ишиг зогсож байв. Гэтэ аварга том чоно орж ирэхэд тэд зугтан нуугдаг. Чоныг гарч явахад тэд эргэж ирсэн болов өөрсдийн дарааллаа мартсан байв. Тэдэнд байра олоход нь тусалж, зөв дарааллан бичээрэй.



3


Хос үгсийг хэлж өгнө. Харин тэдгээр үгсийг утгын хувьд зөв болгон холбож, яагаад? асуултад хариулаарай.

Холбоо үгс:

алим-далай, аяга-гадил, усан онгоц-харандаа, шохой-таваг

Жишээлбэл: Алим-гадил – яагаад гэвэл аль алиныг нь иднэ гэх мэт.





1 Илүүц үгийг олоорой. Өгөгдсөн эгнээ тус бүрээс илүүц үгийг олж, яагаад илүүц болохыг тайлбарлаарай.

№	Өгөгдсөн үгс	Илүүц үг	Яагаад?
1	Үзэг, нохой, харандаа баллуур		
2	Сандал, цэцэг, ор, ширээ		
3	Хус, сарнай, хуш, нарс		
4	Сонгино, эрвээхий, лууван, байцаа		
5	Хонь, үхэр, туулай, тэмээ		

2 Өгүүлбэрийг гүйцээгээрэй.


- Охин чихэр идэх дуртай, яагаад гэвэл
- Аав зураг зурна, яагаад гэвэл
- Эгч бүжиг бүжиглэнэ, яагаад гэвэл
- Орой бид уулзана, яагаад гэвэл
- Дүү шүлэг уншина, яагаад гэвэл

3 Хоорондоо холбоогүй 2 үгийг оролцуулан, өгүүлбэр зохиогоорой.

Жишээ нь : Чихэр-мод - Хэрвээ модон дээр алим ургадаг шиг чихэр ургавал сайхан шүү.

гол - дэвтэр	
цүнх - үүл	
машин - ой	
эрвээхий - утас	
далай - таваг	





1 Уншиж өгсөн үгтэй холбогдох зургийг сонгон холбож, тайлбарлаарай.



Өгөгдсөн үгс:

өвөл,

хайр,

бороо,

өвлийн өвгөн



2 Зөв харгалзуулаарай.

Монгол

Улаанбаатар

Хан-Уул

Сэлэнгэ

хот

дүүрэг

аймаг

улс



3 Өгөгдсөн үгсэд хамаарал бүхий үгсийг олж бичээрэй.

Өгөгдсөн үгс:

✓Данх – ус, аяга, гал тогоо, ээж, өглөөний цай, халуун дулаан гэх мэт

✓Муур – ...

✓Ширээ – ...

✓Хувцас – ...

✓Халбага – ...

✓Үс – ...


✓Ном – ...

✓Гэр – ...

4 “Тооны машин болж тоглоцгооё” .

Хүүхдүүд тойрог болж сууна. Эхний хүүхэд нэг бүхэл тоо хэлнэ. Дараагийн хүүхэд “+”, “-” аль нэгийг хэлнэ. Дараагийн хүүхэд ямар нэгэн тоо хэлэхэд 4 дэх хүүхэд хариуг хэлэх маягаар үргэлжилнэ.





1 Өгүүлбэрийг өөрт ойлгомжтойгоор бүдүүвч зургаар илэрхийлээрэй. 30-40 минутын дараа зургаа харж өгүүлбэрийг сэргээн санаарай.



1. Зам дээр мод ургаж байна.



Blank rectangular box for drawing.

1. Хүү цанаар гулгаж байна.

Blank rectangular box for drawing.

3. Бороо орж байна.

2 Өгөгдсөн зүйлсийг харьцуулж, гол ялгаа ба ижил төстэй зүйлийг олж хэлээрэй.

Харьцуулах зүйлс	Ижил тал	Ялгаатай тал
 ба 		
Чоно ба нохой		
Онгоц ба шувуу		


3 Танай гэрийн эргэн тойрон юу, юу байдаг вэ ? нэрлэж бичээрэй.



Нэрлэж бичих хэсэг :

Large empty rectangular box for writing.

Three empty circles for rating.



- 1 Өгөгдсөн үлгэрт төлөвлөгөө гаргацгаая. Төлөвлөгөөний дагуу үлгэрийг сэргээн санаж яриарай.

Ухаант туулай

Эрт урьд цагт унага хээр унтаж байгаад эхээсээ төөрч хоцорч гэнэ. Тэгээд ганцаараа ижил олон сүрэг, ээжийгээ хайж яваад нэгэн ууттай зүйлтэй таарчээ.

Унага ууттай зүйлийг ихэд сонирхон онгойлгож үзмээр санагджээ. Тэгээд уутны амыг тайлтал дотроос нь өлөн хөх чоно араа шүдээ ярзайлган үсрэн гарч ирээд:

- Чоно: Ха ха ходоод гэдэс хонхолзож байна гэж жигтэйхэн. Хурмаст тэнгэр үүнийг мэдээд надад амтат зөөлөн зоог явуулжээ гээд унагыг идэхээр завдаж гэнэ.

Унага ч маш их айн сандарч яахаа мэдэхгүй бүлтэлзэн байтал бутан дундаас бор туулай дэгдэн дэгдэн гарч ирж гэнэ. Туулай явдал учрыг дуулсны эцэст, чоно гуай, чоно гуай та энэ өчүүхэн жижиг уутанд багтаж байсан гэж үү? би лав итгэхгүй байна. Хэрвээ багтвал би унагатай хамт өөрийгөө ч бас идүүлье гэж гэнэ.

Чоно магад уутанд багтах нь дамжиггүй тул, харин унаган дээрээс туулайг нэмээд зооглох боллоо хэмээн сэтгэж зөвшөөрөөд уут руу орохоор болжээ. Тэгээд уут руу уухилан ортол туулай, тээр хэлээгүй юу сүүл нь багтахгүй байна гэхэд чоно сүүлээ уутанд хийтэл, унага туулай хоёр эвлэн уутны амыг нь сайн боогоод хээр орхижээ.

Ингэж унага ухаант туулайн ачаар чононд идүүлэх аюулаас аврагдсан гэнэ лээ.



- 2 Уншаад, утгыг ойлгохгүй байгаа үгээ доорх хэсэгт бичих, утгыг нь олж мэдээрэй.

Яагаад үлгэрийг “Ухаант туулай” гэж нэрлэсэн бэ?

Үлгэрийг хэд хэдэн утгат хэсэгт хуваагаарай. Төлөвлөгөө гаргаарай.

